

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аялал жуулчлал, амралтын “Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: ОРА-2024/08/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2024 он	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: Б.Азжаргал Утас: 70357955 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.03.15 № 93

танай _____-ны № _____-т

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, АМРАЛТЫН
"ИХ ШҮТЭЭН ЦОГЦОЛБОР"
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.МӨНХТОГОО ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Аялал жуулчлал, амралтын "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Аялал жуулчлал, амралтын "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ -ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд тушаал шийдвэргүй 140.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон, байгууллагын хөрөнгөд 2023 оны хагас жилийн тооллого хийгээгүй, нийт ажилтан албан хаагчдад 1-12 дугаар сарын цалинг бодож олгоходоо цагийн бүртгэлийг үндэслэлгүй олгосон, түрээсийн орлого 5,000.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн, Аялал жуулчлал, амралтын "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ-ын захирал нь өөрийн хамаарал бүхий Жалданжанчүвлин хийдтэй хийдийн үйл ажиллагаа явуулах ажлын байр түрээслэх гэрээ байгуулсан байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох хэсэг, заалттай нийцэхгүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Анхан шатны баримтын бүрдэл хангах, түүнд хяналт хэрэгжүүлсэн байдал үр нөлөөгүй байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэлээр илэрч байна.

Аймгийн Засаг даргын орлогчийн 2024 оны А/90 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн тайланд "Хангалтгүй" үнэлгээ өгч 5 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитын гол асуудал

2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гадна автомашины зогсоолыг 352,178.5 мянган төгрөг, 108 шатны их засаврын ажлыг 133,618.9 мянган төгрөг нийт 485,797.4 мянган төгрөгийн ажлыг үндсэн хөрөнгөд хүлээн авч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аялал жуулчлал, амралтын "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ нь хийдийн үйл ажиллагаа явуулах гэрээг Жалданжанчүвлин хийдтэй байгуулан сар бүр 500.0 мянган төгрөгийн түрээсийг Эрдэнэт санд төвлөрүүлэхээр заасан боловч бүрэн төвлөрүүлээгүй байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан, аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	134,093,726.67	104,220,872.11
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,594,717,168.65	3,940,760,706.28
	Нийт хөрөнгийн дүн	472,254,806.53)	4,044,981,578.39
	Нийт өр төлбөрийн дүн	0	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	472,254,806.53)	4,044,981,578.39
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	472,254,806.53)	4,044,981,578.39
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	50,788,037.00	69,993,569.24
	Үйл ажиллагааны зардлын дүн	209,834,198.52	238,621,421.14
	Үйл ажиллагааны үр дүн	209,834,198.52	238,621,421.14
	Үйл ажиллагааны бус үр дүн	(166,846,161.52)	(168,627,851.90)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(166,846,161.52)	(168,627,851.90)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,205,925,201.85	4,205,925,201.85
	Тайлант оны үр дүн	4,400,541,172.85	(672,729,171.31)
	Эцсийн үлдэгдэл	485,797,428.75	485,797,428.75
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	50,788,037.00	98,657,891.24
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	73,310,234.51	80,692,093.80
	Үйл ажиллагааны ЦМГ	(22,522,197.51)	17,965,797.44
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0	0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(22,522,197.51)	17,965,797.44
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(22,522,197.51)	17,965,797.44
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	419,298.67
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(22,522,197.51)	17,965,797.44
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	0	0
	Урсгал зардал	0	0
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	0	0
	Улсын төсвөөс санхүүжих	0	0
	Орон нутгийн төсвөөс	0	0

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,140.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 5,140.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 3 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Төлбөрийн акт:

Илрүүлэлт:

Тушаал шийдвэргүй 140,625 төгрөгийн илүү цагийн хөлс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт:

Түрээсийн орлого 5,000,000 төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28.5-д "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна", 65.2-д "Түрээсийн гэрээний үндсэн дээр төрийн өмчийн эд хөрөнгийг ашиглах хуулийн этгээд, хувь хүнийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулна" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага:

Илрүүлэлт:

Байгууллагын хөрөнгөд 2023 оны хагас жилийн тооллого хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 1/үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/; 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт:

Нийт ажилтан албан хаагчдад 1-12 дугаар сарын цалинг бодож олгохдоо цагийн бүртгэлийг үндэслэлгүй олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84.5-д "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй", 107.1-д "Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар,

хийснээр, бусад хэлбэрээр тооцно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт:

Аялал жуулчлал, амралтын "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ-ын захирал нь өөрийн хамаарал бүхий Жалданжанчүвлин хийдтэй хийдийн үйл ажиллагаа явуулах, ажлын байр түрээслэх гэрээ байгуулсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 65.2-д "Түрээсийн гэрээний үндсэн дээр төрийн өмчийн эд хөрөнгийг ашиглах хуулийн этгээд, хувь хүнийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулна" гэж заасантай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтны тушаал гаргахдаа батлагдсан орон тоо, төсвөөр цалинжуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Их шүтээн" ОНӨААТҮГ-ын орон тоо, цалин хөлс"-тэй тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тушаал шийдвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргах.

Илрүүлэлт: Худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийхдээ төлбөрийн баримт, нэхэмжлэхийг ажил үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ зэргийг бараа, ажил үйлчилгээ тус бүрээр авч байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аялал жуулчлал, амралтын "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аялал жуулчлал, амралтын "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ	7	5,140.6		5,140.6	3	0	2	0				
Дүн	7	5,140.6			3	0	2	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудитад хамрагдсан	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таатгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ		1	1				1		